


ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

ХУДАГ УСТ ЦЭГ, ЦООНОГ ГАРГАХ
АЖЛЫН ДААЛГАВАР



2020.01.09

Чойбалсан хот

1. Байршил:

- 1.1. Баянтүмэн сум, 2 дугаар баг, Цагаан Х 114°02'84", У 47°07'85.3"
- 1.2. Булган сум, Чулуут баг, Бургаст Х 114°10'58.5", У 47°30'48"
- 1.3. Гурванзагал сум, Рашаант баг, Хулстайн нуур Х 115°11'51", У 48°52'55"
- 1.4. Гурванзагал сум, Рашаант баг, Зүүн ямаат Х 114°53'54", У 48°52'55"
- 1.5. Гурванзагал сум, Рашаант баг, Улаан толгой Х 115°24'21", У 49°26'79.8"
- 1.6. Гурванзагал сум, Цагаан хошуу баг, Шандатын нуур Х 114°39'57.3", У 49°08'95"
- 1.7. Матад сум, Буян-Өндөр баг, Булан цайдам Х 116°16'080", У 47°03'.35"
- 1.8. Матад сум, Жаргалант баг, Тоот Х 115°15'569", У 47°41'42.5"
- 1.9. Халхгол сум, Ялалт баг, Бухцайн зүүн салаа Х 118°07'12'00", У 47°47'24"
- 1.10. Халхгол сум, Ташгай баг, Баруун баян Х 118°20'11.94", У 47°14'53'
- 1.11. Хөлөнбуйр сум, Баян-Өлзийт баг, Намсрайн давааны урд Х 112°54'20.01", У 47°39'31"
- 1.12. Хөлөнбуйр сум, Батхаан баг, Дэрс хонхор Х 112°24'30.11", У 48°07'58'
- 1.13. Чойбалсан сум, Хулстай баг, Мөнхөтийн зүүн урд Х 114°09'133.6", У 38°32'93.6" зэрэг байршлийн ойролцоо усны ундрага сайтай газарт гүн өрмийн худгийн цооног гаргана.

2. Худгийн цооног гаргахад тавигдах шаардлага:

Уст цэг, цооног гаргах ажлыг "Худгийн цооног өрөмдөх, тоног төхөөрөмж суурилуулах ажилд тавих техникийн шаардлага" MNS 6088:2010 стандартын дагуу "Усны мэргэжлийн байгууллага" хийж гүйцэтгэнэ.

| № | Үзүүлэлтүүд |
|--|---|
| 1. Цооног өрөмдөх, цооногийг тоноглох | |
| 1.1 | Геофизикийн судалгаа хийж, худгийн байршлыг эцэслэн тогтооно. |
| 1.2 | Өрөмдмөл худгийн цооногийн ашиглалтын ундарга нэг цагт 2 м ³ -ээс 6 м ³ ус өгөх хүчин чадалтай байна. |
| 1.3 | Суултын болон шүүрийн яндангийн материал нь ган буюу зөвшөөрөгдсөн хуванцар яндан байна. |
| 1.4 | Ус өргөх ган буюу зөвшөөрөгдсөн хуванцар яндангийн диаметр 32 мм байна. |
| 1.5 | Цооног дахь суултын яндан, шүүр нь 20-оос доошгүй жил ашиглах нөхцлийг хангасан байвал зохино. |
| 1.6 | Ус шүүх хайрга нь шигшсэн, мөлгөр хэлбэртэй, тоосонцор хольцгүй, мөхлөгийн хэмжээ 9 мм –ээс томгүй байна. |
| 1.7 | Цооногийн ундарга 1.5 л/секундээс дээш |
| 1.8 | Худгийн шавхалт хийх хугацаа 24 цаг байна. |
| 1.9 | Худгийн уснаас дээж авч шинжилгээ хийлгэсэн байна. |
| 1.10 | Худгийг түр хугацааны аюулгүй байдлын шаардлага хангасан тагаар тоноглох шаардлагатай. |

| 2. Худгийн насос, цахилгааны утас, хянах самбар | |
|--|--|
| 3.1 | Гүний насос:ISO9001 стандартын шаардлага хангасан. Монгол орны уур амьсгалын нөхцөлд ашиглах боломжтой байна. Гарал үүслийн гэрчилгээтэй, үйлдвэрлэгчийн нэр, хаяг, барааны олон улсын гэрчилгээтэй байна. |
| 3.2 | Цахилгааны утас нь худагт ашиглах шаардлагыг хангасан 3 фазын, насосноос хянах самбар хүртэл үргэлжилсэн (залгаасгүй), ус өргөх янданд 2м тутамд хавчиж тогтооно. |
| 3.3 | Хянах самбар нь асаах, унтраах товчлууртай байна. Насос ажиллаагүй байх үед ногоон гэрэл, хүчдэл өгч ажиллаж байх үед улаан гэрэл асаж байхаар тохируулна. |
| 3. Худгийн ажлыг дуусгаж хүлээлгэж өгөх | |
| 4.1 | Талбайг цэвэрлэнэ. /өрөмдлөгийн шлам, цементний баглаа боодол, хайрга чулуу болон ахуйн хог хаягдал гм/ |
| 4.2 | Худаг, гүний насос, жижиг оврын генераторыг ажиллуулах талбайн сургалтыг худаг ашиглагч нарт хийсэн байна.. |
| 4.3 | Худгийн паспортыг 2 хувь бэлтгэж, баталгаажуулан сумын Засаг даргын Тамгын газарт хүлээлгэж өгнө. |

Монгол Улсын Хөдөө аж ахуйн сайд, Байгаль орчны сайд, Сангийн сайдын 2005 оны 7 дугаар сарын 15-ны өдрийн 101, 189, 194 дүгээр хамтарсан тушаалаар батлагдсан “Инженерийн хийцтэй худаг, уст цэгийг сэргээн засварлах, шинээр гаргах, санхүүжүүлэх, эзэмших, ашиглах нийтлэг журам” –ыг мөрдөнө.